**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:**
**БНА-2023/149/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2023 оны 02 дугаар сарын 24 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цээням<br>Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Азбаяр<br>Утас: 99061429 Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт ........................................

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................

3. Санхүүгийн тайлангийн тодруулга........................................

   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа........................................

   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ........................................

   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал........................................

   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ........................................

4. Аудитын тайлан........................................

   4.1 Ерөнхий зүйл ........................................

   4.2 Материаллаг байдал ........................................

   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт........................................

   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........................................

   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........................................

   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........................................

5. Аудитын илрүүлэлт ........................................

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ........................................


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТАГ | Төрийн аудитын газар |
| ШЕЗ | Шүүхийн ерөнхий зөвлөл |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2023.02.24 № 2/105

танай ______________ -ны № ______________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Д.ЭНХЖАРГАЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 22 зорилтын хүрээнд 91



005020413

арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.2 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **406,418,638.00** | **292,126,912.68** |
| **33** | **АВЛАГА** | 139,885,200.00 | 71,206,974.68 |
| **335** | **Бусад авлага** | 139,885,200.00 | 71,206,974.68 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 139,885,200.00 | 71,206,974.68 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 255,199,438.00 | 197,800,438.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 50,790,800.00 | 00.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 202,848,638.00 | 197,800,438.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 8,058,500.00 | 9,554,400.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 149,192,838.00 | 99,099,888.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 3,040,000.00 | 6,100,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,395,000.00 | 00.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 40,162,300.00 | 82,046,150.00 |
| 35600 | Мал амьтад | 1,560,000.00 | 00.00 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 11,334,000.00 | 23,119,500.00 |
| 36600 | Бусад нөөц | 11,334,000.00 | 23,119,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **7,085,370,768.04** | **7,270,388,029.56** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 7,085,370,768.04 | 7,270,388,029.56 |
| 391 | Газар | 493,380.00 | 493,380.00 |
| **392** | **Биет хөрөнгө** | 6,525,564,387.96 | 6,675,801,649.68 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 6,574,893,110.57 | 6,584,793,110.57 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -645,120,135.06 | -805,825,484.94 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 569,354,000.00 | 786,079,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -303,516,361.22 | -376,154,555.68 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 380,388,084.16 | 535,162,984.16 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -212,833,694.70 | -263,001,721.27 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 348,606,079.06 | 440,941,079.06 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -195,616,694.85 | -235,602,762.22 |
| 39217 | Ном | 9,410,000.00 | 9,410,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 559,313,000.08 | 594,092,999.88 |
| 39301 | Програм хангамж | 96,300,000.00 | 102,780,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -58,299,999.92 | -77,800,000.12 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 549,778,000.00 | 597,578,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -28,465,000.00 | -28,465,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **7,491,789,406.04** | **7,562,514,942.24** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **7,491,789,406.04** | **7,562,514,942.24** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 7,491,789,406.04 | 7,562,514,942.24 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,240,774,740.11 | 1,240,774,740.11 |

| | | | |
|---|---|---|---|
| 51101 | Өмч: - төрийн | 1,240,774,740.11 | 1,240,774,740.11 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 4,815,308,896.85 | 4,886,034,433.05 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 4,815,308,896.85 | 4,815,308,896.85 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 70,725,536.20 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,435,705,769.08 | 1,435,705,769.08 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **7,491,789,406.04** | **7,562,514,942.24** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** / төгрөгөөр /

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **5,240,133,818.17** | **5,410,315,247.68** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **641,380,021.37** | **618,534,661.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 641,380,021.37 | 618,534,661.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 641,380,021.37 | 57,957,061.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 188,581,107.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 99,202,029.00 | 57,957,061.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 353,596,885.37 | 00.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ | 0.00 | 528,644,900.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ | 0.00 | 31,932,700.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,598,753,796.80** | **4,791,780,586.68** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 558,218,496.80 | 1,243,970,886.68 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 99,368,220.80 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 558,218,496.80 | 1,144,602,665.88 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 4,040,535,300.00 | 3,547,809,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 4,040,535,300.00 | 3,547,809,700.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **5,334,305,676.24** | **5,304,240,144.85** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,334,305,676.24** | **5,304,240,144.85** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 5,165,350,207.64 | 5,185,561,655.70 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,155,834,221.00 | 1,224,847,487.85 |
| 210101 | Үндсэн цалин | 1,155,834,221.00 | 1,223,415,100.85 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 1,432,387.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 142,142,605.47 | 144,524,753.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 100,530,470.47 | 95,862,099.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,150,400.00 | 11,494,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,920,300.00 | 10,038,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,278,234.00 | 2,343,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,263,201.00 | 24,787,354.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 315,640,265.00 | 321,458,450.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 20,842,395.00 | 22,485,162.00 |
| 210302 | Түлш, халаалт | 259,532,438.00 | 258,933,446.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 13,665,432.00 | 18,439,842.00 |
| 210304 | Байрны түрээс | 21,600,000.00 | 21,600,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 186,491,383.00 | 198,857,919.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 31,484,224.00 | 27,450,080.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 77,995,900.00 | 74,864,889.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 16,100,033.00 | 23,068,900.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,393,900.00 | 440,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,320,000.00 | 863,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 23,111,048.00 | 22,840,500.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 35,086,278.00 | 49,330,550.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 22,261,850.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 22,261,850.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 85,918,203.00 | 9,992,150.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,755,000.00 | 2,607,000.00 |
| 210602 | Тавилга | 29,670,080.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 52,493,123.00 | 7,385,150.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 59,072,800.00 | 34,892,210.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 29,239,300.00 | 29,521,950.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 29,833,500.00 | 5,370,260.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 594,543,383.00 | 1,329,160,013.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 580,489,210.00 | 1,306,011,614.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 600,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 10,522,000.00 | 7,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 928,004.00 | 1,800,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 176,000.00 | 299,768.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 11,615,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,828,169.00 | 1,833,631.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,603,445,497.17 | 1,921,828,672.85 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,248,901,301.20 | 1,559,821,001.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 11,916,700.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 354,544,195.97 | 350,090,971.85 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 168,955,468.60 | 118,678,489.15 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 56,226,660.00 | 82,663,918.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 21,227,084.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 16,983,736.00 | 56,664,634.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 18,015,840.00 | 25,999,284.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 112,728,808.60 | 36,014,571.15 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 112,728,808.60 | 36,014,571.15 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-94,171,858.07** | **106,075,102.83** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 201,958,333.45 | 35,349,566.63 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 197,000,000.06 | 26,506,666.63 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 4,958,333.39 | 8,842,900.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -201,958,333.45 | -35,349,566.63 |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-296,130,191.52** | **70,725,536.20** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **4,918,719,176.80** | **4,849,737,647.68** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **201,999,272.00** | **57,957,061.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 201,999,272.00 | 57,957,061.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 201,999,272.00 | 57,957,061.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 101,607,203.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 100,392,069.00 | 57,957,061.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,716,719,904.80** | **4,791,780,586.68** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 676,184,604.80 | 1,243,970,886.68 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 99,368,220.80 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 676,184,604.80 | 1,144,602,665.88 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 4,040,535,300.00 | 3,547,809,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 4,040,535,300.00 | 3,547,809,700.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **4,869,247,176.80** | **4,816,767,647.68** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,869,247,176.80** | **4,816,767,647.68** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **4,700,341,708.20** | **4,686,767,383.85** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,142,729,703.00 | 1,224,847,489.85 |
| 210101 | Үндсэн цалин | 824,582,903.40 | 635,118,300.00 |
| 210102 | Нэмэгдэл | 243,154,799.80 | 291,494,613.85 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 74,991,999.80 | 40,877,714.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 257,356,862.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 148,747,233.00 | 144,514,753.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 106,928,500.00 | 94,374,253.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,150,400.00 | 12,535,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,920,300.00 | 10,028,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,230,100.00 | 2,507,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,517,933.00 | 25,070,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 315,640,265.00 | 321,428,450.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 20,842,395.00 | 22,485,162.00 |
| 210302 | Түлш, халаалт | 255,489,323.00 | 258,903,446.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 17,708,547.00 | 18,439,842.00 |
| 210304 | Байрны түрээс | 21,600,000.00 | 21,600,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 147,474,255.00 | 148,572,769.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 33,474,674.00 | 28,975,980.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 77,405,900.00 | 74,864,889.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 17,394,083.00 | 23,068,900.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,076,400.00 | 500,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,320,000.00 | 863,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 16,803,198.00 | 20,300,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,389,000.00 | 2,800,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,389,000.00 | 2,800,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 62,055,290.00 | 25,420,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 996,790.00 | 5,000,000.00 |
| 210602 | Тавилга | 5,224,100.00 | 450,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 55,834,400.00 | 19,970,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 57,739,300.00 | 34,892,210.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 29,239,300.00 | 29,521,950.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 28,500,000.00 | 5,370,260.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 617,124,677.00 | 1,295,212,511.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 603,070,504.00 | 1,268,649,112.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 600,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 10,522,000.00 | 7,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 928,004.00 | 1,800,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 176,000.00 | 299,768.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 15,030,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,828,169.00 | 1,833,631.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,207,441,985.20 | 1,489,079,201.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,207,441,985.20 | 1,477,162,501.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 11,916,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **168,905,468.60** | **130,000,263.83** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 56,176,660.00 | 82,663,918.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 21,027,084.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 16,983,736.00 | 56,664,634.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 18,165,840.00 | 25,999,284.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 112,728,808.60 | 47,336,345.83 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 112,728,808.60 | 36,014,571.15 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **49,472,000.00** | **32,970,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **49,472,000.00** | **32,970,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **49,472,000.00** | **32,970,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 49,472,000.00 | 32,970,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 49,472,000.00 | 32,970,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-49,472,000.00** | **-32,970,000.00** |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,240,774,740.11 | 1,458,307,144.06 | 5,114,304,306.38 | 00.00 | 7,813,386,190.55 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,240,774,740.11** | **1,458,307,144.06** | **5,114,304,306.38** | **00.00** | 7,813,386,190.55 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -296,130,191.52 | 00.00 | -296,130,191.52 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,240,774,740.11** | **1,435,705,769.08** | **4,815,308,896.85** | **00.00** | 7,491,789,406.04 |
| D01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,240,774,740.11** | **1,435,705,769.08** | **4,815,308,896.85** | **00.00** | 7,491,789,406.04 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,240,774,740.11** | **1,435,705,769.08** | **4,815,308,896.85** | **00.00** | 7,491,789,406.04 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 70,725,536.20 | 00.00 | 70,725,536.20 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,240,774,740.11** | **1,435,705,769.08** | **4,886,034,433.05** | **00.00** | 7,562,514,942.24 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** / төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Хэтрэлт, хэмнэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 3,647,809,700.00 | 3,569,752,189.85 | 78,057,510.15 | 97.9 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 3,647,809,700.00 | 3,569,752,189.85 | 78,057,510.15 | 97.9 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,565,106,300.00 | 3,487,088,271.85 | 78,018,028.15 | 97.8 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,253,513,800.00 | 1,224,847,489.85 | 28,666,310.15 | 97.7 |
| 210101 | Үндсэн цалин | 635,118,300.00 | 635,118,300.00 | - | 100.0 |
| 210102 | Нэмэгдэл | 295,435,500.00 | 291,494,613.85 | 3,940,886.15 | 98.7 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 57,960,000.00 | 40,877,714.00 | 17,082,286.00 | 70.5 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 265,000,000.00 | 257,356,862.00 | 7,643,138.00 | 97.1 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 156,689,200.00 | 144,514,753.00 | 12,174,447.00 | 92.2 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 106,548,700.00 | 94,374,253.00 | 12,174,447.00 | 88.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,535,100.00 | 12,535,100.00 | - | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,028,100.00 | 10,028,100.00 | - | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,507,000.00 | 2,507,000.00 | - | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,070,300.00 | 25,070,300.00 | - | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 343,399,300.00 | 321,428,450.00 | 21,970,850.00 | 93.6 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 25,600,000.00 | 22,485,162.00 | 3,114,838.00 | 87.8 |
| 210302 | Түлш, халаалт | 274,899,300.00 | 258,903,446.00 | 15,995,854.00 | 94.2 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 21,300,000.00 | 18,439,842.00 | 2,860,158.00 | 86.6 |
| 210304 | Байрны түрээс | 21,600,000.00 | 21,600,000.00 | - | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 162,422,200.00 | 148,572,769.00 | 13,849,431.00 | 91.5 |
| 210401 | Бичиг хэрэг | 28,983,300.00 | 28,975,980.00 | 7,320.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 88,250,000.00 | 74,864,889.00 | 13,385,111.00 | 84.8 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 23,068,900.00 | 23,068,900.00 | - | 100.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 500,000.00 | 500,000.00 | - | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,320,000.00 | 863,000.00 | 457,000.00 | 65.4 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 20,300,000.00 | 20,300,000.00 | - | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 2,800,000.00 | 2,800,000.00 | - | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,800,000.00 | 2,800,000.00 | - | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 25,420,000.00 | 25,420,000.00 | - | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,000,000.00 | 5,000,000.00 | - | 100.0 |
| 210602 | Тавилга | 450,000.00 | 450,000.00 | - | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 19,970,000.00 | 19,970,000.00 | - | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 35,400,000.00 | 34,892,210.00 | 507,790.00 | 98.6 |
| 210702 | Дотоод албан томилолт | 30,000,000.00 | 29,521,950.00 | 478,050.00 | 98.4 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 5,400,000.00 | 5,370,260.00 | 29,740.00 | 99.4 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 96,084,000.00 | 95,533,399.00 | 550,601.00 | 99.4 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 36,000,000.00 | 36,000,000.00 | - | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 600,000.00 | - | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 7,000,000.00 | 7,000,000.00 | - | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,800,000.00 | 1,800,000.00 | - | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 300,000.00 | 299,768.00 | 232.00 | 99.9 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 48,000,000.00 | 48,000,000.00 | - | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 2,384,000.00 | 1,833,631.00 | 550,369.00 | 76.9 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1489377800.00 | 1489079201.00 | 298,599.00 | 100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,477,461,100.00 | 1,477,162,501.00 | 298,599.00 | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,916,700.00 | 11,916,700.00 | - | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 82703400.00 | 82663918.00 | 39,482.00 | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 82,703,400.00 | 82,663,918.00 | 39,482.00 | 100.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 56,703,400.00 | 56,664,634.00 | 38,766.00 | 99.9 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 26,000,000.00 | 25,999,284.00 | 716.00 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 3,647,809,700.00 | 3,569,752,189.85 | 78,057,510.15 | 97.9 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 3,547,809,700.00 | 3,511,795,128.85 | 36,014,571.15 | 99.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 3,547,809,700.00 | 3,511,795,128.85 | 36,014,571.15 | 99.0 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 100,000,000.00 | 57,957,061.00 | 42,042,939.00 | 58.0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 100,000,000.00 | 57,957,061.00 | 42,042,939.00 | 58.0 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 98.00 | 98.00 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 11.00 | 11.00 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 55.00 | 55.00 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 32.00 | 32.00 | - | 100.0 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газар нь хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд 2020-2024 онд хийж гүйцэтгэхээр төлөвлөөд буй арга хэмжээгээ хэрэгжүүлэхдээ төр, иргэний ашиг сонирхлыг дээдлэн, тэдний оролцоог ханган гүйцэтгэлийн үр дүнгийн талаар жил бүр аймгийн Засаг дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнаж, Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүрсэн түвшнийг баталгаажуулах, тогтвортой ахиулах, сул тал, эрсдэлийг бууруулж, давуу тал, боломжийг ашиглан, Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврыг ханган биелүүлэх, Засаг даргаас шийдвэр гаргахад мэргэжлийн арга зүй, санал зөвлөмжөөр хангаж ажиллахаас гадна Тамгын газрын үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар аймгийн иргэдэд ил тод нээлттэй мэдээлж байхаар төлөвлөсөн болно

- Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй нягт уялдуулах , хэрэгжилтийг хангахад байгууллагын үйл ажиллагааг чиглүүлэх ,

- Тамгын газрын хэлтэс, алба, албан хаагч бүр энэхүү төлөвлөгөөний дагуу жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, мөрдөн ажиллах
- Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг албан тушаалын тодорхойлолтод тусган шинэчлэх
- Стратеги төлөвлөгөөг 2020 оны Баянхонгор аймгийн эдийн засаг, нийгмийн суурь түвшингээс 2021. 2022. 2023. 2024 онд нэмэгдэх бодит ахицыг харгалзан төлөвлөсөн болно.

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67,4, Засгийн газрын 2021 оны "Аймгийн Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай" 377 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны "Журам батлах тухай" 382 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэх тогтоох тухай" 472 дугаар тогтоолыг тус тус үндэслэн 2022 оны 01 сарын 03-ны А/01 тушаалаар Аймгийн Засаг даргын тамгын газрын бүтэц орон тоо батлагдаж Удирдлага 2, Байгууллагын дарга 1, ТАСЗ, ТЗУХ 8, Хууль эрх зүйн хэлтэс 7, СТСХ 8, Нийгмийн бодлогын хэлтэс 6, ХБТХОХ 7, ХШҮХ 4, Цэргийн штаб 3, Төрийн үйлчилгээний албан хаагчид 15, Архивын албан хаагчид 35 орон тоо бүтэц зохион байгуулалттайгаар нийт 97 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа хэрэгжүүлж ажиллаж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Баянхонгор аймаг нь БНСУ-д төвтэй Зүүн Хойд Азийн Нутгийн Захиргаадын Холбоо, БНСУ-ын Кёнги муж, Ансан хотын Данвон эмнэлэг, Чамжиун эмнэлэг, Япон улсын Ойта муж, БНХАУ-ын Альшаа аймаг, Эзнээ хошуу, Нинша Хуйн хотон үндэстний Өөртөө Засах Орон, ОХУ-ын Буриад улсын Кабанский муж, Франц улсын "Сиряк" ХХК, Бүгд Найрамдах Болгар улсын Русе муж, Польш улсын Веунчика хот, Австри улсын Кейртнер хот, АНУ-ын Вүүдсайт хот, Бүгд Найрамдах Унгар улсын Худалдааны Төлөөлөгчийн Газрууд зэрэг 13 хөрш зэргэлдээ гадаадын орнуудтай санамж бичиг байгуулж, гадаад харилцаагаа өргөжүүлэн хамтран ажиллаж байна

Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 агентлаг, 20 сумыг чиг үүргээр ханган Аймгийн Засаг дарга 24 агентлагийн дарга нартай гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажуулж, 20 сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллажээ.

Дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, зардлыг хэмнэж ажилласан. Дотооддоо 1 Төрийн албаны салбар зөвлөл, 6 хэлтэс, 2 алба, 1 тасагт 97 албан хаагчийн орон тоо бүтэцтэйгээр төрийн чиг үүргийг хэрэгжүүлэн үйл ажиллагаа явагдаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

АЗДТГ-ын Удирдлагын 2021 оны 10 сарын 20-ны өдрийн А/177 тоот тушаалаар Дотоод хяналт, шалгалтын ажлын хэсгийн 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан дотоод хяналт шалгалтыг жилд 2-3 удаа зохион байгуулан хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Байгууллагын удирдлагын 2022.05.05-ны өдрийн А/91 тушаалаар 8 гишүүний бүрэлдэхүүнтэй өмч хамгаалах зөвлөлийг байгуулан байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавин ажиллаж, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн мэдээллийг хагас бүтэн жилээр шинэчилж ажиллаж байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 7,491,789.4 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 70,725.5 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 139,885,2 | 71,206,9 | (68,678,3) |
| Бараа материал | 255,199,4 | 197,800,4 | (57,399,0) |
| Үндсэн хөрөнгө | 7,085,370.7 | 7,270,388.0 | 185.017.3 |
| **Нийт хөрөнгө** | **7,491,789.4** | **7,562,514.9** | 70.725.5 |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | **7,491,789.4** | **7,562,514.9** | 70.725.5 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **7,491,789.4** | **7,562,514.9** | 70.725.5 |

Эх сурвалж: Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан

Авлага дансны үлдэгдэл тайлант оны эхэнд 139,885.2 сая төгрөгийн өвс, махны тээвэрлэлт, борлуулалтай холбоотой авлагатай 2021 оны аудитын дүгнэлтээр шүүхийн шийдвэрт шилжүүлж шалгагдаж дүгнэлт гарсан. Шүүхийн шийдвэрээр махны 20,000.0 мянган төгрөгийг "Натураль грийн пүүдс" компани эргэн төлөхөөр, 80,000.0 мянган төгрөгийг Аймгийн онцгой комиссын шийдвэрээр балансаас хасах дүгнэлт гарсан. Авлага 80,000.0 мянган төгрөгөөр буурсан.

Бараа материалын дансны үлдэгдэл 197,800.4 мянган төгрөг болж өмнөх оноос 57,399.0 мянган төгрөгөөр буурсан бөгөөд төсвийн хөрөнгөөр 216,662.9 мянга, үнэ төлбөргүй 31,932.7 мянган төгрөгийн орлого авч 236,035.6 мянган төгрөг зарцуулж, 8,842.9 мянган төгрөг шилжүүлэн 49,330.6 мянган төгрөгийн бараа материал акталж устгасантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,270,388 мянган төгрөг болж 185,316,5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр нийт 32,970.0 мянга, үнэ төлбөргүй 516,919.9 мянга, балансаас балансt 11,725.0 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч, 33,600.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл шилжүүлсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,562,514.9 мянган төгрөг болж 70,725.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д заасны дагуу төсвийг зарцуулахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-дэх заалтыг тус тус мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 3,547,890.7 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 100,000,0 төгрөг нийт зарлагыг 3,647,890.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 942,400,5 мянган төгрөгөөр бууруулж 3,647,809,7 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70106 хөтөлбөрийн 80101, 80112, 80205, 80802, 81102 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,547,809,7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.
Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 3,547,809,7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, зарцуулагдаагүй 36,014,5 мянган төгрөгийг буцаан төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3.569.752.1 мянган төгрөг буюу 97.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 78.057.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага | 3,647,809.7 | 3,569,752.1 | 78,057.5 | 97.9% |
| 2 | 80101 үндсэн үйл ажиллагааны зардал | 1,339,082.0 | 1,333,019.2 | 6,062.7 | 99.5% |
| 3 | 80112 Нийтлэг үйлчилгээ | 641,524.3 | 611,910.3 | 29,613.9 | 95.3% |
| 4 | 80205 Мэдээлэл сурталчилгааны зардал | 36,000.0 | 36,000.0 | 0 | 100.0% |
| 3 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал | 82,703.4 | 82,663.9 | 39.5 | 99.9% |
| 4 | 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө | 1,448,500.0 | 1,448,201.6 | 298.4 | 99.9% |
| | Нийт дүн | 3,647,809.7 | 3,569,752.1 | 78,057.5 | 97.9% |

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн 100030051406 тоот дансанд 1.234.970,8 мянган төгрөгийн орлого орж 1,223,649,1 мянган төгрөгийг зарцуулж зарцуулаагүй 11,321,7 мянган төгрөгийг буцаан орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

| № | Гүйлгээний утга | 2021 оны буцаан олгосон санхүүжилт | Орлого | Зарлага | Үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|
| 1 | Тусгай зөвшөөрөл | | 1,885,0 | - | 1,885,0 |
| 2 | Туслах үйл ажиллагааны орлого | 3,060,6 | 1,587,5 | 4,648,1 | - |
| 3 | Архивын ерөнхий газар /Гэрээт операторчдын цалин/ | | 27,687,0 | 27,687,0 | - |
| 4 | Техник хяналт /Гэрээт ажилтны цалин ХОХБТХ/ | | 5,078,4 | 5,078,4 | - |
| 5 | Удирдлагын академи /Сургалтын төлбөр/ | | 1,664,0 | 1,664,0 | - |
| 6 | ТАЗ-ийн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх 7.1.2 | | 29,216,0 | 29,216,0 | |
| 7 | НҮБ-ын хүүхдийн сан | | 20,602,4 | 20,602,4 | - |
| 8 | НҮБ- Утаагүй Баянхонгор | 80,000,0 | 163,672,0 | 243,672,0 | - |
| 9 | НҮБ УАЦЭА | 1,307,6 | 265,585,0 | 257,455,8 | 9,436,7 |
| 10 | ХБИ-ийн төвийн цалин | | 46,117,1 | 46,117,1 | - |
| 11 | EB-AUSTRALIAN EMBASSY- DAP TRANCHE | | 62,640,9 | 62,640,9 | - |
| 12 | Соёлын хэлтэс | 15,000,0 | | 15,000,0 | - |
| 13 | АИТХ-ын даргын 2023 оны Захирамж ¹ 36 37 | | 5,000,0 | 5,000,0 | - |
| 14 | БОДЬ ДААТГАЛ ХК | | 3,867,7 | 3,867,7 | - |
| 15 | НҮБ Наранбаяр, Жаргалмаа | | 40,849,1 | 40,849,1 | |
| 16 | 100900011001 Сангийн Яам | | 100,000,0 | 100,000,0 | - |
| 17 | Угийн бичиг | | 1,128,6 | 1,128,6 | - |
| 18 | 100900013003 БОАЖЯам Төрийн сан | | 258,108,4 | 258,108,4 | - |
| 19 | 100900011001 Сангийн Яам Төрийн сан | | 100,000,0 | 100,000,0 | - |
| 20 | 100900013003 БОАЖЯам /ОББҮХ 2022-157 гэрээт ажил/ | | 9,913,0 | 9,913,0 | - |
| 21 | Орон нутагт татан төвлөрүүлэлт | | | 11,321,7 | |
| | ДҮН | 99,368,2 | 1,144,602,6 | 1,243,970,8 | 11,321,7 |

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

| № | Хөтөл бөр | Эдийн засгийн ангилал | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 70706-80101 | 210101-210104 | 2022-01-01 2022-12-31 | Цалингийн сүлжээ болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу тогтоон олгож байгаа тушаалын үндсэн цалин. Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын дагуу, Төрийн албаны тухай болон бусад хууль, тогтоомжийн дагуу олгож байгаа нэмэгдэл цалингууд үндсэн цалингаас хувиар бодож бүй тогтоон олгож буй цалин. Удирдлага 2, Байгууллагын дарга 1, ТАСЗөвлөл 1, ТЗУХэлтэс 8, Хууль эрх зүйн хэлтэс 7, СТСхэлтэс 8, Нийгмийн бодлогын хэлтэс 6, ХБТХОХэлтэс 7, ХШҮХэлтэс 4, Цэргийн штаб 3, Төрийн үйлчилгээний албан хаагчид 15, Архивын албан хаагчид 35 орон тоо бүтэц зохион байгуулалттайгаар нийт 97 албан хаагчийн 1-12 дугаар сарын цалинг бодож олгосон. | 97,7% | 1,253,513,8 | 1,224,847,4 |
| | | 210201-210205 | 2022-01-01 2022-12-31 | Тайлангийн хугацаанд нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын хуульд заасан хувь хэмжээгээр үндсэн болон нэмэгдэл цалин түүнтэй адилтгах орлогоос төлөх нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тооцож бүртгэнэ. Алба хаагчдын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээ тайланг сар бүр төлж, өр авлагагүй ажилласан. | 92,2% | 156,689,2 | 144,514,7 |
| | | 210301 | 2022-01-01 2022-12-31 | АЗДТГ-ын барилгын Архивын тасгийн барилгын гэрэл цахилгааны зардлыг г үйлчлэгч байгууллагатай байгуулсан гэрээ, цахилгаан эрчим хүч хэмжих тоолуурын заалтын дагуу ашигласан цахилгаан эрчим хүчний төлбөрийн дагуу төлж барагдуулсан. | 87,8% | 25,600,0 | 22,485,1 |
| | | 210302 | 2022-01-01 2022-12-31 | АЗДТГ-ын барилгын Архивын тасгийн барилгын халаалтыг үйлчлэгч байгууллагатай хийсэн гэрээний дагуу төлж барагдуулсан. | 94,2 | 274,889,3 | 258,903,4 |
| | | 210303 | 2022-01-01 2022-12-31 | Чандмань-Баянхонгор ХК-ай байгуулсан гэрээний дагуу байгууллагын дотоод хэрэгцээнд төвлөрсөн хамгамжаас ашигласан цэвэр, бохир усны төлбөрийг тоолуурын заалтын дагуу 100 хувь шилжүүлсэн. | 86,6% | 21,300,0 | 18,439,8 |
| | | 210304 | 2022-01-01 2022-12-31 | Байгууллагын үндсэн үйл ажиллагаа эрхлэн явуулахдаа бусдын өмчийн байрыг түрээсээр ашигласны төлбөрийг байгууллагатай гэрээ байгуулсаны дагуу төлбөрийг төлж барагдуулсан. | 100% | 21,600,0 | 21,600,0 |
| | | 210401 | 2022-01-01 2022-12-31 | Байгууллагын хэвийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах бичиг хэргийн зардлыг нээлттэй тендэр зарлан шалгарсан байгууллагатай гэрээ байгуулан шаардлагатай тоо хэмжээгээр татан авч албан хаагчдыг бичиг хэргийн материалаар хангаж, сар бүрийн 25-ны дотор тооцоог хийж ирсэн. | 100% | 28,983,3 | 28,975,9 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 210402 | 2022-01-01 2022-12-31 | Байгууллагын өөрийн автотээврийн хэрэгсэлд зарцуулах шатах тослох материал, бусдын тээврээр гэрээ байгуулсаны үндсэн дээр ажил, үйлчилгээ гүйцэтгүүлсэний хөлс, байгууллагын өөрийн болон бусдын тээврээр түлш бэлтгэхтэй холбогдон гарах бензин, шатахууны зардлыг үйлчлэгч байгууллагатай байгуулсан гэрээний дагуу гарсан төлбөр тооцоог төлж ирсэн. Улирал бүр төлбөр тооцоог тулган баталгаажуулж ирсэн. | 84,8% | 88,250,0 | 74,864,8 |
| | | 210403 | 2022-01-01 2022-12-31 | АЗДТГазар, Архивын тасаг, Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн 70440001 шуурхай дуудлагын утас, бусад албан хаагчдын суурин утас, интернетийн төлбөр, бичиг, захидал шуудангаар явуулах зэрэг гарсан зардлыг 100 хувь төлж барагдуулан ажилласан. | 100% | 23,068,9 | 23,068,9 |
| | | 210404 | 2022-01-01 2022-12-31 | Байгууллагын албан хэрэгцээнд ашиглах дотоодын тогтмол хэвлэл захиалахад төлбөр тооцоог хийсэн. | 100 | 5,000,0 | 5,000,0 |
| | | 210405 | 2022-01-01 2022-12-31 | Төрийн үйлчилгээг хэвийн явуулахад байгууллага чиг үүргээ хэрэгжүүлсэний дүнд бий болох хог хаягдал,ариутгал цэвэрлэгээ, том оврын хог хаягдлыг устгах, тээвэрлэхтэй холбоотой зардлыг Цэвэр хот ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээний дагуу төлж барагдуулсан. | 65,4 | 1,320,0 | 863,0 |
| | | 210406 | 2022-01-01 2022-12-31 | Байгууллагын цэвэрлэгээ үйлчилгээний материал, ариутгал халдваргүйжүүлэлтийн төлбөрийг 100 хувь төлж, алба хаагчдын цэвэр тохитой орчинд ажиллах, ээлжийн алба хаагчид үүргээ гүйцэтгэх нөхцөл боломцоо хангагдсан. | 100% | 20,300,0 | 20,300,0 |
| | | 210503 | 2022-01-01 2022-12-31 | Үйлчилгээний ажилтны хувцас, хөдөлмөр хамгаалын хувцас худалдан авахдаа "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмын дагуу,байгууллагын үндсэн үйл ажиллагааны зориулалтаар цөөн тоогоор худалдан авсан зардлыг төлж барагдуулсан. | 100% | 2,800,0 | 2,800,0 |
| | | 210601-210604 | 2022-01-01 2022-12-31 | Байгууллагын өөрийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй барилга байгууламж, авто тээврийн хэрэгсэлд урсгал засвар хийхтэй холбогдон гарсан зардал, засвар үйлчилгээний материал авах, багаж, техник хэрэгсэл худалдан авахдаа "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмын дагуу,байгууллагын үндсэн үйл ажиллагааны зориулалтаар цөөн тоогоор худалдан авсан зардлыг төлж барагдуулсан. | 100% | 25,420,0 | 25,420,0 |
| | | 210702-210703 | 2022-01-01 2022-12-31 | Байгууллагын удирдлага болон эрх бүхий бусад байгууллагын шийдвэрийн дагуу тусгайлсан удирдамжаар албан томилолтоор ажиллахад гарах тээврийн зардал, байр, хоолны зардлыг ССайдын баталсан нормативын дагуу олгож ирсэн. Зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг удирдлагын шийдвэр, төсөв, нээхмжлэлийг үндэслэн олгож ирсэн. | 98,4% | 35,400,0 | 34,892,2 |
| | | 210802-210807 | 2022-01-01 2022-12-31 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг төлөхдөө гүйцэтгэгч байгууллагатай байгуулсан гэрээ, нэхэмжлэхийг үндэслэн төлж барагдуулсан. | 99% | 60,084 | 59,533,3 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 210901 | 2022-01-01 2022-12-31 | Бусад бүлэгт хамааруулах боломжгүй бусад бараа үйлчилгээний зардлыг байгууллагын удирдлагын шийдвэрийн дагуу олгож ирсэн. | 99,9% | 1,478,580,0 | 1,477,162,4 |
| | | 210902 | 2022-01-01 2022-12-31 | Албан хаагчдын мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах, сургалт семинарт хамруулах зорилгоор болон, сургалт, зөвлөгөөн зохион байгуулахад шаардагдах сургалтын төлбөр зэрэг холбогдон гарах шийдвэр, бэлтгэн нийлүүлэгчийн нэхэмжлэх болон бусад холбогдох баримтын дагуу зардлыг олгож ирсэн. | 100% | 11,916,7 | 11916,7 |
| | | 210801 | 2022-01-01 2022-12-31 | Мэдээлэл, сурталчилгааны зардлыг гүйцэтгэгч байгууллагатай байгуулсан гэрээ, нэхэмжлэх, тайланг үндэслэн олгож ирсэн. | 100% | 36,000,0 | 36,000,0 |
| | | 213207-213209 | 2022-01-01 2022-12-31 | Албан хаагчдын Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж, Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллыг холбогдох хууль журмын дагуу батлагдсан төсвийн хуваарийн дагуу олгож ирсэн. | 99.9% | 82,703,4 | 82,663,9 |

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цэзням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн.

2022 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Энхжаргал, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч С.Гэрэлмаа нар зурж байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 5,304,240.1 мянган төгрөгөөс 53,042.4 мянган төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 37,129.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн хуультай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2022 онд нийт 6,567,720.8 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 143 мэдээллийг хугацаанд нь 6 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд байршуулсан | Хугацаа хоцроож байршуулсан | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 10 | 1 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | 0 |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 3 | 1 | 0 |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 33 | 3 | 0 |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 95 | 1 | 0 |
| 6 | Нийт | 27 | 151 | 143 | 6 | 2 |

Аудитаар тендер шалгаруулах худалдан авах ажиллагаа-1, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 6,567,720.8 мянган төгрөгийн 12 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 2,398,407.4 мянган төгрөгийн 145 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой төгрөгийн 206 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгээгүй.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар 155,705.8 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснээс 56,477.7 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, 99,228.1 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн ба Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022.05.30-ны өдрийн 1/1134 дүгээр албан бичгээр хэрэгжилтийг тооцсон байна.

*Хүснэгт 5. Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 3 | 56,477.7 | 2 | 43,794.0 | 77.5 |
| Зөвлөмж | 2 | 99,228.1 | 2 | 99,228.1 | 100 |
| **Нийт дүн** | **5** | **155,705.8** | **4** | **143,022.1** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 333,638.7 мянган төгрөгийн 7 зөрчил[1] илэрч, 333,638.7 мянган төгрөгийн 6 зөрчилд зөрчил арилгах 4 албан шаардлага өгч, төсвийн төлөвлөлттэй холбоотой 1 зөвлөмж өгөв.

### 5.1 Албан шаардлага

1. Ажлаас үндэслэлгүйгээр чөлөөлсөн Б.Ишмаагийн ажилгүй байсан хугацааны цалин 3,747.6 мянган төгрөг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Төсвийн хөрөнгөөс шилжүүлсэн 3,747.6 мянган төгрөгийг буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар төсөвт буцаан төлүүлэх албан шаардлагыг Аймгийн ЗДТГ-ын даргад хүргүүлэв.

2. "Баянжаргалант хүнс" ХХК 5,000.0 мянга, "МЦ ЭНХ" ХХК 4800,0 мянга, "Хонгор инженеринг" ХХК 1,705.0 мянга, нийт 11,505.0 мянган төгрөгийн гүйлгээг Е баримтгүй хийж 1,150.5 мянган төгрөг төсөвт төвлөрөх боломжийг алдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан “20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т “Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Бэлтгэн нийлүүлэгчээр баримтыг нөхөн шивүүлж, төсөвт 11,505.0 мянган төгрөгт ногдох 1,150.5 мянган төгрөгийг оруулах нөхцөлийг бүрдүүлэх албан шаардлага өгөв.

3. БОАЖГ-аас Баянхонгор аймгийн Нам даралтын зуухнуудад "утаа шүүгч" шинээр суурилуулах арга хэмжээнд 660,000.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулж, 258,108.4 мянган төгрөгийн урьдчилгаа санхүүжилт олгож 2022.12.31-нд ажил бүрэн дуусахаар гэрээ хийсэн боловч тухайн ажил бүрэн хийгдэж дуусаагүй байна.

Энэ нь Иргэний хуулийн 350.1-д заасан "Ажил гүйцэтгэгч нь дараах үүрэг хүлээнэ", 350.1.1-д "гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Гүйцэтгэгчээр ажлыг бүрэн гүйцэтгүүлж комиссоор хүлээн авч төсвийн хөрөнгийн үр ашгийг гаргах албан шаардлага өгөв.

4. Хөрөнгө оруулалтаар Угалз 4 багийн 7-р гудамжийг жишиг гудамж төслийн хүрээнд "Номгон такс констракшн" ХХК-тай 2022.07.22-ний өдөр 100,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, ажлыг 2022.08.22-ний өдөр дуусгаж хүлээлгэж өгөхөөр гэрээнд заасан байхад хугацаандаа өгөөгүй, 70,632.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байхад тухайн ажил бүрэн хийгдэж дуусаагүй байна.

Энэ нь Иргэний хуулийн 350.1-д заасан "Ажил гүйцэтгэгч нь дараах үүрэг хүлээнэ", 350.1.1-д "гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: "Номгон такс констракшн" ХХК-аар ажлыг бүрэн хийлгэж төсвийн хөрөнгийн үр ашгийг гаргах албан шаардлага өгөв.

**5.2. Зөвлөмж**

1. Шилэн дансны цахим сайтад тогтмол зардлын болон ажил гүйцэтгэх гэрээ, бусад худалдан авалттай холбоотой гэрээг байршуулаагүй, мөн 6 мэдээг хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-т заасан Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Шилэн дансны цахим сайтад цахилгаан эрчим хүч, халаалт, цэвэр бохир усаар үйлчлэх болон бусад гэрээг цаг тухай бүрд нь мэдээлж байх зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх шийдвэрийн биелэлтийг нотлох баримтын хамт Төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор албан бичгээр хариуг ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ /мянган төгрөг/

| Зөрчлийн утга | Нийт зөрчил | | Үүнээс: | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ажлаас үндэслэлгүйгээр чөлөөлсөн Б.Ишмаагийн ажилгүй байсан хугацааны цалин 3,747.6 мянган төгрөг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан. | 1 | 3,747.6 | | | 1 | 3,747.6 | | |
| "Баянжаргалант хүнс" ХХК 5,000.0 мянга, "МЦ ЭНХ" ХХК 4800,0 мянга, "Хонгор инженеринг" ХХК 1,705.0 мянга, нийт 11,505.0 мянган төгрөгийн гүйлгээг Е баримтгүй хийж 1,150.5 мянган төгрөг төсөвт төвлөрөх боломжийг алдсан байна. | 1 | 1,150.5 | | | 1 | 1,150.5 | 0 | 0 |
| БОАЖГ-аас Баянхонгор аймгийн Нам даралтын зуухнуудад “утаа шүүгч” шинээр суурилуулах арга хэмжээнд 660,000.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулж, 258,108.4 мянган төгрөгийн урьдчилгаа санхүүжилт олгож 2022.12.31-нд ажил бүрэн дуусахаар гэрээ хийсэн боловч тухайн ажил бүрэн хийгдэж дуусаагүй байна. | 1 | 258,108.4 | | | 1 | 258,108.4 | | |
| Хөрөнгө оруулалтаар Угалз 4 багийн 7-р гудамжийг жишиг гудамж төслийн хүрээнд "Номгон такс констракшн" ХХК-тай 2022.07.22-ний өдөр 100,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж ажлыг 2022.08.22-ний өдөр дуусгаж хүлээлгэж өгөхөөр гэрээ байгуулж 70,632.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байхад тухайн ажил бүрэн хийгдэж дуусаагүй байна. | 1 | 70,632.2 | | | 1 | 70,632.2 | | |
| **ДҮН** | **4** | **333,638.7** | | | **1** | **333,638.7** | **0** | **0** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим сайтад цахилгаан эрчим хүч, цэвэр бохир усаар үйлчлэх гэрээг байршуулаагүй | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| **Дүн** | **1** | | **0** | **0** | **0** | **0** | **1** | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Нийт дүн** | **1** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **1** | **0** |

-oOo-